



ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

(Эпидемиологийн 1 дүгээр долоо хоног)

Нэг. Угаарын хийн хордлогын шалтгаант үйл явдлын мэдээ


- Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаар 79 иргэн угаарын хийн хордлогод өртсөн. Үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буцсан 65, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан 12, нас барсан 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1. Угаарын хийн цочмог хордлогын тохиолдол, байршлаар

Үзүүлэлт		Хүний тоо
Угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандсан хүний тоо		79
Мэдээ ирүүлсэн эрүүл мэндийн байгууллага		
ХЯТҮТ-д хандсан		26
ЭХЭМҮТ-д хандсан		24
Нийслэлийн эрүүл мэндийн газар		21
Аймгийн ЭМГ, НЭ		8
Эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байдал		
Хэвтэн эмчлүүлсэн		65
Зөвлөгөө, эмчилгээ аваад буцсан		12
Нас барсан		2
Хүн ам зүйн байдал		
Хүйсээр:	Эрэгтэй	36
	Эмэгтэй	43
Насны ангиллаар:	Насанд хүрэгчид	42
	Хүүхэд /0-17/	37
Улаанбаатар хот:		Хороо/Хүний тоо
		16/70
Дүүргээр:	Сонгинохайрхан	3/15
	Баянзүрх	5/22
	Баянгол	0/0
	Сүхбаатар	1/1
	Чингэлтэй	5/21
	Хан-Уул	1/1
	Налайх	1/10
	Тодорхойгүй	0
Хөдөө орон нутаг:		Сум/Хүний тоо
		3/9
Аймгаар:	Баянөлгий аймаг	1/3
	Сэлэнгэ аймаг	1/5
	Өвөрхангай аймаг	1/1

Дотоод албан хэрэгцээнд


- 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн буюу 1 дүгээр долоо хоногт угаарын хийн хордлого өмнөх оны мөн үеэс 7%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 32%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Байршлаар авч үзвэл БЗД, СХД-т зонхилон бүртгэгдсэн.



Зураг 1. Угаарын хийн хордлогын тохиолдол, долоо хоногоор

Хоёр. Химийн бодисын цочмог хордлогын мэдээ

- Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаар 15 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буцсан 8, хэвтэн эмчлүүлж байгаа 7 тохиолдол бүртгэгдсэн байна.
- 2025 оны 1 дүгээр долоо хоногт химийн цочмог хордлогод өртсөн 15 хүн (хүүхэд-4, насанд хүрэгчид-11) хандаж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Өмнөх оны мөн үеэс 20%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 58%-иар өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 2. Химийн хордлогын тохиолдол, долоо хоногоор

Хүснэгт 2. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (ХЯТҮТ, ЭХЭМҮТ)

№	Шалтгаан	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	4	7
2	Эмийн хордлого	6	2	8
Нийт		9	6	15

- Санаатай буюу амиа хорлох зорилгоор эм, химийн бодис ууж, хордлогод өртсөн 9 тохиолдол бүртгэгдсэн ба 19-с 56 насныхан байна.